

ДААЛГАВРЫН ХАРИУ, ҮНЭЛЭХ АРГАЧЛАЛ

Даалгавар	Зөв хариулт. Хувилбар "А"	Зөв хариулт. Хувилбар "В"	Оноо	Онооны тайлбар
1	С	В	1	
2	В	А	1	
3	В	А	1	
4	Д	С	1	
5	С	В	1	
6	А	Д	1	
7	С	Д	1	
8	Д	С	1	
9	В	Д	1	
10	Д	С	1	
11	С	С	1	
12	В	С	1	
13	А	С	1	
14	А	С	1	
15	С	В	1	
16	В	В	1	
17	В	В	1	
18	В	Д	1	
19	С	С	1	
20	Д	В	1	
21	А	В	1	
22	С	В	1	
23	А	А	1	
24	Д	А	1	
25	С	В	1	
26	Д	В	1	
27	В	Д	1	
28	А	Д	1	
29	В	Д	1	
30	В	А	1	
31	Д	С	1	
32	А	А	1	
33	С	В	1	
	Хоёр. Задгай даалгавар			
34.1	Ардчилсан	Ардчилсан бус	1	
34.2	Давуу тал нь иргэн бүрийн санал бодол шийдвэрт тусгагдана. Иргэдийн оролцоо хангагдана.,гэх мэт	Дарангуйлагч дэглэм учраас сонгууль хэлбэрийн төдий явагддаг. Чөлөөт ардчилсан сонгууль болдоггүй.	2	Аль нэгийг нь сонгоод жишээгээр тайлбарласан бол 1 оноо, 2 болон түүнээс дээш жишээгээр тайлбарласан бол 2 оноо
34.3	Сул тал нь цаг хугацаа их алдана., санал зөрөлдөнө. Хүн бүрийн санал авах тул санал зөрнө, оновчтой шийдэлд хүрч чадахгүй.,,,, гэх мэт	Ардчилсан бус буюу дарангуйлагч дэглэмтэй улс. Төрийн эрх мэдэл хуваарилагдаагүй бөгөөд төвлөрсөн. Иргэд төрийн хэрэгт оролцох боломж байхгүй.	2	Аль нэгийг нь сонгоод жишээгээр тайлбарласан бол 1 оноо,2 болон түүнээс дээш жишээгээр тайлбарласан бол 2 оноо
35.1	Лигдэн хаан	40 гаруй	2	Зөв хариулт 2 оноо, Хариулт буруу бол 0 оноо
35.2	Ар элстэйн чуулган	Мандухай сэцэн хатан	2	Зөв хариулт 2 оноо, Хариулт буруу бол 0 оноо
35.3	Урвагч ноёдын үйл ажиллагаанаас хамаарч	Даяар олныг захирах	2	Зөв хариулт 2 оноо,Дөхүүлсэн бол 1оноо,Хариулт буруу бол 0 оноо
35.4	Шашин шүтлэг, эрхлэх аж ахуй төстэй учраас ийм шийдвэр гаргасан.	Улс орон нэгдэж нэгэн хааны захиргаанд орсон үе	2	Зөв хариулт 2 оноо, Дөхүүлсэн бол 1 оноо Хариулт буруу бол 0 оноо
35.5	Монголын ард түмэн эрх чөлөөгүй болж бусдын дарлалд зовж зүдэрсэн.	Нэгдсэн их Монгол улсыг сэргээх далд санаатай байсан.	2	Зөв хариулт 2 оноо, Дөхүүлсэн бол 1 оноо Хариулт буруу бол 0 оноо
35.6	XVII зууны I хагас	XV зууны II хагас- XVI зууны I хагас	2	Зөв хариулт 2 оноо,Аль нэгийг бичсэн бол 1 оноо Хариулт буруу бол 0 оноо

ХУВИЛБАР ” А”

80 минут

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР: Сонгох даалгавар бүр 1 оноотой.

1. **Хүн төрөлхтний эртний иргэншил үүссэн “Тигр”, “Евфрат” мөрнүүд хаанаас эх авч хаана цутгадаг вэ?**
 - A. Төвдийн тэгш өндөрлөгөөс эх авч Шар тэнгист цутгана.
 - B. Умард Африкийн тэгш өндөрлөгөөс эх авч Газар дундын тэнгист цутгана.
 - C. Бага Азийн өндөр уулсаас эх авч Персийн буланд цутгана.
 - D. Андын нуруунаас эх авч Атлантын далайд цутгана.
2. **Бичиг үсэг үүсэхээс өмнөх нэн эртний түүх соёлыг ямар судалгаагаар илрүүлэн судалдаг вэ?**
 - A. Бичгийн эх сурвалж B. Археологийн судалгаа
 - C. Аман зохиолын сурвалж D. Шашны зан үйл
3. **Монгол нутагт дахь эртний улсуудыг оршин байсан дарааллаар нь зөв эрэмбэлсэнг олно уу.**
 - A. Хүннү, Сянби, Нирун, Уйгар, Түрэг B. Хүннү, Сянби, Нирун, Түрэг, Уйгар
 - C. Хүннү, Нирун, Сянби, Түрэг, Уйгар D. Хүннү, Сянби, Уйгар, Түрэг, Нирун
4. **Монголчууд ХХ зууны эхэн үе ядуу буурай орон болсны гол шалтгааныг сонгоно уу.**
 - A. Нүүдлийн мал аж ахуй хоцрогдон аж үйлдвэр хөгжөөгүй учир
 - B. Гадаадаас зээл тусламж авч байгаагүй учир
 - C. Ноёд язгууртнууд ард иргэдээс маш их хэмжээний татвар авч байсан учир
 - D. Тусгаар тогтнолоо алдаж харь улсын эрхшээлд орсон учир
5. **1907 оны Орос Японы гэрээний гол агуулгыг зөв тодорхойлсонг сонгоно уу**
 - A. Гадаад Монголын тусгаар тогтнолыг тууштай дэмжинэ гэж тохиролцсон
 - B. Өвөр Монголоос бусад Монголчуудыг нэгтгэх нь зөв гэж үзсэн
 - C. Гадаад монгол дахь Оросын нөлөөг хүлээн зөвшөөрсөн
 - D. Гадаад монгол дахь Японы нөлөөг хүлээн зөвшөөрсөн
6. **Хүмүүсийн хооронд үүсэх таагүй харилцааг илэрхийлсэн хэлц үг аль нь вэ?**
 - A. Гар бариад бугуй барих B. Гараа гарган хийх
 - C. Гар барих D. Гар нийлэх
7. **Монголд болсон бүх ард түмний анхны санал хураалт хэдийд ямар асуудлаар явагдсан бэ?**
 - A. 1911 оны 12 сарын 29-нд Олноо өргөгдсөн Монгол улсын дээд доод хурлыг сонгоход
 - B. 1922 оны Ардын Түр цагийн хурлын төлөөлөгч сонгоход
 - C. 1945.10.20-нд Монгол улсын тусгаар тогтнолыг зөвшөөрөх эсэх асуудлаар
 - D. 1924 онд үндсэн хуулиа батлахад
8. **1990 оны 3 сарын 4-нд 100 гаруй мянган хүн оролцсон цуглаан жагсаалыг зохион байгуулж, нам төрийн удирдагчдад хүргүүлсэн шаардлагад аль нь хамааралгүй вэ?**
 - A. Намын үйл ажиллагааг төрөөс тусгаарлах B. Шинэ үндсэн хууль, сонгуулийн хуулийн төсөл боловсруулах
 - C. Сонгуулиар шинэ төр байгуулаад, хуучин төр огцрох
 - D. 1960 оны үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж засах
9. **Инфляцийн түвшин тогтмол өсөж байгаа үед аль нь үнэн, зөв дүгнэлт вэ?**
 - A. Бодит цалин нэрлэсэн цалингаас их B. Нэрлэсэн цалин бодит цалингаас их
 - C. Нэрлэсэн болон бодит цалингийн тоон хэмжээ ижил D. Бодит цалин ямагт их
10. **Дараах өгөгдлөөс буруу бодомжийг сонгоно уу.**
 - A. Ёс заншил нь тухайн ард түмэнтэй үүссэн. B. Ёс заншил нь залуу үеийг хүмүүжүүлэхэд чухал үүрэгтэй.
 - C. Ёс заншил өмнөх үеийн ололт амжилтад тулгуурладаг. D. Ёс заншлыг залуу үе бүтээдэг.
11. **Ээж нь өсвөр насны охиндоо санаа зовдог тул түүний цахим шууданг шалгадаг. Энэ нь охины ямар эрх зөрчигдөж байна вэ?**
 - A. Амьд явах эрх B. Эвлэлдэн нэгдэх эрх C. Халдашгүй чөлөөтэй байх D. Эрүүл байх эрх
12. **“Монголын нууц товчоонд”-нд бичсэнээр Хабул хан өөрийн долоон хөвүүнээ байтал Монгол улсын хаан ширээг хэнд гэрээсэлсэн байдаг бэ?**
 - A. Бартан баатар B. Амбагай C. Сача бэх D. Жамуха
13. **Варвар хэмээх үгийн утгыг зөв тайлбарласанг сонгоно уу.**
 - A. Зэрлэг, бүдүүлэг гэсэн үг B. Герман овог аймаг гэсэн үг
 - C. Нүүдэлчид гэсэн үг D. Тариачид гэсэн үг
14. **Монголчуудын Боржигин овог хэнээс үүссэн бэ?**
 - A. Бодончар B. Алангоо эх C. Хабул хан D. Чингис хаан
15. **Ардчилсан дэглэмтэй улсын шинжийг аль нь илэрхийлэхгүй байна вэ?**
 - A. Хууль тогтоогчид ард иргэдийн саналыг сонсдог.
 - B. Иргэдийн санал болгосон хуулийн төслийг хэлэлцэнэ.
 - C. Тус улсад сонгууль болдоггүй бөгөөд ганц нам дангаар төр барина.
 - D. Ард түмнээс сонгогдсон парламент хууль батална.

16. Улс төрийн бутралын үе нь хэддүгээр зуун хамаардаг вэ?

- A. XII-XIII зуун B. XIV-XVI зуун C. XI-XVI зуун D. XII-XVII зуун

17. Монголын "Дөчин түмэн Монголын эзэн" хэмээн өөрийгөө өргөмжилж Манжийн хаан Нурхачийг "мөрөн голын хөвөөнд суух гурван түмнийг захирсан өчүүхэн хан" хэмээн Лигдэн хаан өгүүлсэн. Энэ захианы ач холбогдлыг зөв тайлбарласныг сонгоно уу.

- A. Монголчууд Манжийн хаан нурхачитай захиагаар харьцаж байсан
 B. Монголчууд шинээр мандан гарч буй Манж улсад шахалт үзүүлж, буулт хийлгэх далд санаа агуулж байсан
 C. Хөрш улсуудтай найрсаг харилцаатай байхыг зорьж байсан
 D. Цэргийн давуу байдлыг ашиглан эзлэн түрэмгийлэхийг зорьж байсан

18. Иргэн С нь захиргааны байгууллага, албан тушаалтны гаргасан шийдвэрийг хууль бус, эрхийг нь зөрчсөн гэж үзэж шүүхэд ханджээ. Иргэн С нь захиргааны шүүх хуралдаанд оролцогч аль талыг төлөөлөх вэ ?

- A. Гуравдагч этгээд B. Нэхэмжлэгч C. Хариуцагч D. Өмгөөлөгч

19. Константинополь хотыг яагаад "Алтан гүүр" хэмээн нэрлэж байсан бэ?

- A. Баруун, зүүн европыг холбосон худалдааны зам дайрдаг байсан учраас
 B. Юстиниан хаан хүч чадлаа харуулах гэж алтан гүүр барьсан учраас
 C. Ази Европыг холбосон худалдааны зам дайрдаг байсан учраас
 D. Дорно зүгийн орнуудаас их хэмжээний татвар хурааж байсан учраас

20. Цахим сүлжээний эерэг талыг илэрхийлэх жишээ аль нь вэ?

- A. Цахим орчинд хуурамч мэдээлэл тараах B. Нууц нэрээр хаяг нээх, юу дуртайгаа бичих
 C. Цахим орчинд бүдүүлэг үг хэллэг хэрэглэх D. Мэдээлэл авах, ашиглах, харилцаагаа өргөжүүлэх

21. Энэтхэгийн кастын тогтолцоог зөв тохируулна уу.

1. Брахман	2. Кшатри	3. Вайши	4. Шудра
а. Газаргүй тариачид. Еюолууд	б. Тариачид, урчууд, худалдаачид	с. Хамгийн дээд эрх мэдэлтэй санваартнууд	д. Цэргийн жанжид, язгууртнууд

- A. 1с, 2D, 3б, 4а B. 1б, 2а, 3с, 4D C. 1а, 2с, 3D, 4б D. 1D, 2б, 3а, 4с

22. Дараах хүний эрхүүдээс иргэний болон улс төрийн эрхэд хамаарахыг сонгоно уу?

- A. Хөдөлмөрлөх B. Соёлын амьдралд оролцох C. Гэрлэх эрх тусгаарлах эрх
 D. Нийгмийн халамж, хамгаалал хүртэх

**23. 1682 онд I Петр хаан Оросын хаан ширээнд суув. Тэрээр дотоод гадаад бодлогоо шинэчлэн, Орос улс түүхийн тавцанд сэргэн босож ирэв. Түүний нэг илрэл нь тухайн үеийн тайж нарын хувцаслалт байв. Зургийг ажиглаад .
 XVIII зууны үетэй холбогдох зургийг сонгоно уу.**

A.



C



B.



D.



24. Зэргэлдээ ангийн дуулдаг охин Э-д нөгөө ангийн Б охин дургүй. Учир нь сүүлийн 2 жил урлагийн наадамд Э охин түрүүлж байгаа бөгөөд Б түүний дараа буюу дэд байрыг эзэлж байгаа. Үүнээс үүдэлтэй тэр хоёрын хооронд зөрчил үе үе үүсдэг. Анги ахихын хэрээр 2 охин бие биенээ ойлгохыг хичээж хэд хэдэн удаа ярилцаж үзсэн. Хамгийн сүүлчийн уулзалтаар тэд хоёр талынхаа ашиг сонирхолыг дээд зэргээр хангасан хамтын шийдэлд хүрсэн. Энэ нь зөрчилдөөнийг шийдвэрлэх хандлагын аль нь вэ?

- A. Сөргөлдөх B. Буулт хийх C. Зайлсхийх D. Хамтран ажиллах

25. Эстрадын дуу соёлын аль хэлбэрт багтах вэ?

- A. Ардын соёл B. Сонгодог соёл C. Нийтийн соёл D. Уламжлалт соёл

26. Монгол улс НҮБ-ын энхийг сахиулах ажиллагаанд оролцсоноор ямар үүрэг хүлээх болсныг тодорхойлж зөв хариултыг сонгоно уу.

- A. Бүс нутгийн аюулгүй байдлыг бий болгох үүрэг хүлээсэн. B. Хүн амын бичиг үсгийн боловсролыг хөгжүүлсэн.
 C. Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс нутаг болсон. D. НҮБ-ын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болсон.

27. Хөдөлмөрийн үнэ буюу хүний хөдөлмөрийг ашигласны төлөө түүний тоо, чанарт тохируулан төлж байгаа мөнгөн төлбөрийг..... гэнэ

- A. Өртгийн хэмжүүр B. Цалин C. Үнэлгээ D. Ноогдол ашиг

28. Солонгос улсад хөдөлмөрийн гэрээгээр ажилчид гаргах, Алтанбулгийн эдийн засгийн чөлөөт бүс байгуулах зэрэг нь ажилгүйдлийг бууруулах дараах арга замуудын аль нь вэ?

- A. Гадаад хүчин зүйлийг ашиглах B. Захиргааны арга
C. Хувийн зохион байгуулалтын D. Эдийн засгийн арга

29. Ардчилсан нийгмийн үед хууль тогтоохдоо баримталдаг зарчим аль нь вэ?

- A. Богино хугацаанд тогтвортой хэрэгжиж чадахуйц хууль боловсруулах B. Иргэдийн оролцоог хангах
C. Цөөнхийн эрх ашигт нийцүүлэх D. Хууль нь тодорхой бүлэглэлийн эрх ашигт үйлчилдэг байх

30. Зөв харгалзуулна уу

- | | |
|------------|-----------------------------------|
| A Тушаал | 1 Засгийн газар |
| B Зарлиг | 2 Аймаг, нийслэлийн засаг дарга |
| C Тогтоол | 3 Ерөнхийлөгч |
| D Захирамж | 4 Засгийн газрын агентлагын дарга |

- A. A1, B3, C4, D2 B. A4, B3, C1, D2 C. A3, B2, C1, D4 D. A4, B1, C3, D2

31. Дамжуулахыг зорьж буй мэдээллээ үг болон дохио зангаа зэргээр илгээх үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ?

- A. Тайлах B. Саад C. Илэрхийлэх D. Илэрхийлэх

32. Нийгмийн байр сууль, боловсролын түвшин, нутаг ус, сэтгэлзүйн байдлыг үгэн бус харилцааны аль онцлогоос мэдэх боломжтой вэ?

- A. Дуу хоолой B. Орон зай C. Гар хөлийн байрлал, хөдөлгөөн D. Нүүр хувирал

33. НТӨ 198 онд Хүннү гүрэн Хан улсын хооронд анхны гэрээ байгуулагдсан бөгөөд уг гэрээний үр дүнг доорх

..... өгөгдлөөс сонгоно уу.

- A. Хан улс Хүннүгийн харьяат болсон B. Хүннү улс Хан улсад дагаар орсон
C. Хоёр тал хилээ тогтоож Хан улс Хүннүд алба татвар төлөх болсон
D. Хүннү улс Хан улсад алба татвар өгөхөөр болсон

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР:

34. Хууль тогтоогчид хотын бүх иргэдийн сар бүрийн нээлттэй хурал дээр иргэдийн санал болгосон хуулийн төсөл боловсруулна. Дараа нь тэр төслийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар иргэдийн санал хураана.

a. Дээрх жишээнд дурдагдаж буй улс нь төрийн ямар дэглэмтэй вэ? / 1оноо/

b. Иргэдийн саналыг авч шийдвэрлэхийн давуу талыг бичнэ үү. ? / 2оноо/

c. Иргэдээс санал авч шийдвэрлэхийн сул талыг бичнэ үү. ? / 2оноо/

35. Дараах эх сурвалжийг анхааралтай уншиж асуултад хариулна уу.

Манжийн хаанд дагаар орж, 1636 онд Өвөр Монголын 16 аймгийн 49 ноёдын чуулган Мүгдэнд болж, Умард Алтан улсын хаан Абахайг Монголын хаанд өргөмжилжээ. 1688 онд Галдан бошгот хаан Түшээт хан болон Занабазар нартай нэгдэн Манжийн эсрэг тэмцэхийг зорьсон боловч Түшээт хан нар Манжийн нутагт зугтан гарсан. Халхын ноёд 1688 оны 9 сард Ар элстэй гэдэг газар чуулган чуулж Занабазар “Хойд зүгийн шар Хятад (Орос) хэмээх улсын хааны төр амгалан, их улс боловч шажин эс дэлгэрсэн бөгөөд бас ч хувцадын зах буруу тул үл болмуй. Өмнө зүгийн хар Хятад (Манж -С.Ц.) хэмээх улсын хааны төр төвшин амгалан сайны дээр бас түүнд бурхны шашин дэлгэрсэн, ялангуяа Манжийн хааны эд агуурс нь тэнгэр лусын эд эрдэ- нэсийн хив хадаг, торго тэргүү- тэн бүрдсэн их буянтай хаан мөний тул тэр зүг явбаас, төр тогтож, хамаг амьтан жарга- муй” хэмээн өгүүлснээс үүдэн Халх Манжид дагаар орох шийдвэр гаргажээ.

a. Монголын сүүлчийн хаан хэн бэ? / 2оноо/

b. Халх Монголыг манжид дагаар орох шийдвэрийг хаана болсон чуулганаар хэлэлцэн гаргасан бэ? / 2оноо

c. Халх Монгол ямар шалтгааны улмаас Манжид дагаар орох шийдвэр гаргасан бэ? / 2оноо/

d. Занабазар яагаад Манжид дагаар орох шийдвэр гаргасныг тайлбарлан бичнэ үү. / 2оноо /

e. Анхдугаар богд Жавзундамбын Манжид дагаар орох болсон шийдвэр нь бидэнд ямар сургамжийг үлдээсэн бэ? / 2оноо/

f. Өвөр Монгол Манжид эзлэгдсэн 1636 оныг зуунд шилжүүлнэ үү. / 2оноо/

Хариултын хуудас

ХУВИЛБАР “А”

..... сургуулийн ангийн суралцагч овогтой

Даал гавар	Оноо	Суралцагчийн хариулт	Багшийн үнэлгээ
1	1		
2	1		
3	1		
4	1		
5	1		
6	1		
7	1		
8	1		
9	1		
10	1		
11	1		
12	1		
13	1		
14	1		
15	1		
16	1		
17	1		
18	1		
20	1		
21	1		
22	1		
23	1		
24	1		
25	1		
26	1		
27	1		
28	1		
29	1		
30	1		
31	1		
32	1		
33	1		
34	1		
	2		
	2		
35	2		
	2		
	2		
	2		
	2		
	2		

Нийт авсан оноо:

Гүйцэтгэлийн хувь:

Үр дүнгийн үнэлгээний түвшин:

Шалгасан багшийн нэр, гарын үсэг:

“НИЙГМИЙН УХААН” ХИЧЭЭЛ УЛСЫН ШАЛГАЛТ. IX АНГИ /нэгдмэл агуулга/

Дорнод аймгийн Боловсрол, шинжлэх ухааны газар

ХУВИЛБАР “В”

80 минут

НЭГ. СОНГОХ ДААЛГАВАР: Сонгох даалгавар бүр 1 оноотой.

1. **Хүн төрөлхтний эртний иргэншил үүссэн "Нил" мөрөн хаанаас эх авч хаана цутгадаг вэ?**
 - A. Төвдийн тэгш өндөрлөгөөс эх авч Шар тэнгист цутгана.
 - B. Умард Африкийн тэгш өндөрлөгөөс эх авч Газар дундын тэнгист цутгана.
 - C. Бага Азийн өндөр уулсаас эх авч Персийн буланд цутгана.
 - D. Андын нуруунаас эх авч Атлантын далайд цутгана.
2. **Тухайн орон нутгийн иргэдтэй уулзаж, өөрийн нутаг ус, түүх соёл, удам угсаа шашин шүтлэг, зан заншлынх ... нь талаар ярилцах замаар цуглуулсан баримтыг.....гэнэ.**
 - A. Аман түүх
 - B. Домог яриа
 - C. Аян замын тэмдэглэл
 - D. Бодит түүх
3. **Бодит цалингийн хэмжээг илэрхийлэх өгөгдлийг олно уу?**
 - A. Нэрлэсэн цалинг инфляцийн түвшинд харьцуулна.
 - B. Нэмэгдэл хөлсийг инфляцийн түвшинд харьцуулна
 - C. Үндсэн цалинг бодит цалинтай харьцуулна
 - D. Бодит цалинг үндсэн цалинтай харьцуулна
4. **Хүннүүд бичиг үсэгтэй байсан гэж үзэх шалтгааныг доорх өгөгдлөөс сонгоно уу.**
 - A. Тэдний Хан улсад явуулсан захидал Хятад улсын музейд бий учир
 - B. Хүннү улсын түүхийг өгүүлсэн бичээс бүхий хад олдсон учир
 - C. Хүннүгийн булшнаас бэхийн дурсгалтай бийрний нийлүүр олдсон учир
 - D. Ноён уулнаас олдсон ширмэл ширдэгт тэдний бичиг үсгийн дурсгал үлдсэн байдаг учир
5. **Эргүнэ гүний домгийн гол агуулгыг зөв тодорхойлсныг сонгоно уу.**
 - A. Түрэг аймгийг Монголчууд цохин мөхөөж тэд Эргүнэ гүнд очиж нутагласан тухай
 - B. Түрэгүүдэд цохигдсон Монголчууд Эргүнэ гүнд очиж нутаглан өсөж үржсэн тухай
 - C. Эргүнэ гүнд Монголчууд 1000 орчим жил амьдарсан тухай
 - D. Эргүнэ гүнд Монгол, Түрэг аймгууд хамт 400 орчим жил оршин сууж, өнөржин олширсон тухай
6. **1911 оны 12 сарын 29 билгийн тооллын ямар жилийн хэдэн сарын хэдэн байсан бэ?**
 - A. Улаагчин хулгана жилийн намрын адаг сарын шинийн найман
 - B. Цагаагчин гахай жилийн өвлийн эхэн сарын шинийн найман
 - C. Цагаагчин хулгана жилийн өвлийн дунд сарын шинийн есөн
 - D. Цагаагчин гахай жилийн өвлийн дунд сарын шинийн есөн
7. **Хүмүүсийн хооронд үүсэх эерэг харилцааг илэрхийлсэн хэлц аль нь вэ?**
 - A. Гар бариад бугуй барих
 - B. Гар хоосон
 - C. Гар татах
 - D. Гар нийлэх
8. **Монголд болсон бүх ард түмний анхны санал хураалт хэдийд ямар асуудлаар явагдсан бэ?**
 - A. 1911 оны 12 сарын 29-нд Олноо өргөгдсөн Монгол улсын дээд доод хурлыг сонгоход
 - B. 1922 оны Ардын Түр цагийн хурлын төлөөлөгч сонгоход
 - C. 1945.10.20-нд Монгол улсын тусгаар тогтнолыг зөвшөөрөх эсэх асуудлаар
 - D. 1924 онд үндсэн хуулиа батлахад
9. **1990 оны 3 сарын 4-нд 100 гаруй мянган хүн оролцсон цуглаан жагсаалыг зохион байгуулж, нам төрийн удирдагчдад хүргүүлсэн шаардлагад аль нь хамааралгүй вэ?**
 - A. Намын үйл ажиллагааг төрөөс тусгаарлах
 - B. Шинэ үндсэн хууль, сонгуулийн хуулийн төсөл боловсруулах
 - C. Сонгуулиар шинэ төр байгуулаад, хуучин төр огцрох
 - D. 1960 оны үндсэн хуульд нэмэлт өөрчлөлт оруулж засах
10. **Соёлын өв болон түүний хэлбэрийг зөв холбоосыг олно уу?**
 - A. Соёл-Соёлын өв-ажилгүйдэл
 - B. Соёлын өв-Биет бус өв-хиргисүүр
 - C. Соёлын өв-Биет өв-хөшөө
 - D. Соёлын өв-Биет өв-ёс заншил
11. **Дараах хүний эрхүүдээс иргэний болон улс төрийн эрхэд хамаарахыг сонгоно уу.**
 - A. Хоол хүнсээр хангагдах эрх
 - B. Хөдөлмөрлөх эрх
 - C. Үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх эрх
 - D. Сурч боловсрох эрх
12. **Эргүнэ гүн хэмээх газар хаана байдаг вэ?**
 - A. Байгаль нуурын баруун хэсэг
 - B. Хөвсгөл нуурын баруун хэсэг
 - C. Хянганы нурууны зүүн хэсэг
 - D. Алтайн нурууны өмнөд хэсэг
13. **Дундад зууны Европын нийгэмд 400 орчим жил үргэлжилсэн шилжилт хөдөлгөөн ямар нэрээр түүхэнд тэмдэглэгдсэн байдаг бэ?**
 - A. Үндэстэн дамнасан нүүдэл
 - B. Ард түмний их нүүдэл
 - C. Европын ард түмнүүдийн нүүдэл
 - D. Ази руу чиглэсэн их нүүдэл
14. **Баруун Европт дундад зууны үед баригдсан байгууламжуудаас Ахен дахь эзэн хааны ордны сүм өдгөө уламжлагдаж иржээ. Энэхүү сүм одоогийн аль улсын нутагт оршдог вэ?**
 - A. Их британи
 - B. Испани
 - C. Герман
 - D. Грек
15. **Дарлигин аймаг хэмээх ойлголтод ямар аймгууд багтах вэ?**
 - A. Хүннүгийн угсааны Монгол аймаг
 - B. Эргүнэ гүнд байсан Монгол аймгууд
 - C. Түрэгт захирагдсан Монгол аймгууд
 - D. Алангоо эхийн хөвгүүдээс салбарласан аймгууд
16. **Ардчилсан бус дэглэмтэй улсын шинжийг аль нь илэрхийлэхгүй байна вэ?**
 - A. Улсын тэргүүн ард түмнээс сонгогдохгүй эцгээс өвлөдөг.

- В. Ард түмнээс сонгогдсон парламент хууль батална.
 С. Тухайн улсын ерөнхийлөгчийн сонгуульд нэг л хүн нэр дэвших бөгөөд түүнтэй хэн ч өрсөлддөггүй.
 Д. Тус улсад сонгууль болдоггүй.
17. Иргэн Д дүүргийн засаг даргын захирамжийн дагуу газар эзэмшиж байв. Гэтэл засаг даргын зүгээс захирамж гарган уг газрыг давхцуулан иргэн Н-д олгосон учир Д захиргааны хэргийн шүүхэд хандав. Уг хэргийн хариуцагч нь хэн бэ?
 А. Шүүгч В. Засаг дарга С. Иргэн Д Д. Иргэн Н
18. "Өр Монгол" гэж ямар монголчуудыг нэрэлдэг вэ?
 А. Хавт хасарын угсааныхан В. Баатар гэсэн утгатай олон тооны нэр
 С. Бэлгүтэйн угсааныхан Д. Зүүн Монголоос ойрадад очигсогд
19. 1640 онд Тарвагатайн Улаан бураа хэмээх газар Монгол-Ойрадын их цаазыг батлан гаргасны ач холбогдлыг зөв тайлбарласныг сонгоно уу.
 А. Их Монгол улсаас хойш нэгэн хуулийн дор нэгдсэн үйл явдал болсон
 В. Өвөр Монгол, Ойрад Монголын нөлөө бүхий ноёд дотоодын эв нэгдлээ хангахын тулд нэгдэн нийлсэн үйл явдал болсон
 С. Манж Чин улсын түрэмгийллийн эсрэг дотооддоо хууль эрхзүйн хүрээнд нэгдэн нийлсэн үйл явдал болсон
 Д. Бүх Монголчууд дотооддоо хууль эрхзүйн хүрээнд нэгдэн нийлсэн үйл явдал болсон
20. Монголын "Дөчин түмэн Монголын эзэн" хэмээн өөрийгөө өргөмжилж Манжийн хаан Нурхачийг "мөрөн голын хөвөөнд суух гурван түмнийг захирсан өчүүхэн хан" хэмээн Лигдэн хаан өгүүлсэн. Энэ захианы ач холбогдлыг зөв тайлбарласныг сонгоно уу.
 А. Монголчууд Манжийн хаан нурхачитай захиагаар харьцаж байсан
 В. Монголчууд шинээр мандан гарч буй Манж улсад шахалт үзүүлж, буулт хийлгэх далд санаа агуулж байсан
 С. Хөрш улсуудтай найрсаг харилцаатай байхыг зорьж байсан
 Д. Цэргийн давуу байдлыг ашиглан эзлэн түрэмгийлэхийг зорьж байсан
21. "Шинэ засгийн бодлого" хэмээх ойлголтод хамаарахгүй асуудал аль нь вэ?
 А.Хятад иргэдийг Монголд нүүлгэх товчоог Бээжинд байгуулсан
 В.Шашны асуудалд анхаарч лам нарыг төрөөс ангид байлгахыг зорьсон
 С.Монголчуудыг хятадчлах бодлого барьсан
 Д.Газар тариалан эрхлүүлэх нэрийдлээр олон хятад иргэн Монголд орж ирсэн
22. Төрөөс иргэдэд үзүүлж буй үйлчилгээг бүх хүн амд хүртээмжтэй, чанартай, тасралтгүй хүргэхийн тулд төрийн захиргааны алба чиг үүрийнхээ дагуу иргэдэд үйлчилдэг. Төрийн захиргааны алба, иргэдийн авах үйлчилгээг зөв харгалзуулна уу.
 А. Нийгмийн даатгал 1. Гадаад паспорт
 В. Иргэний бүртгэл 2. Асаргааны тэтгэмж
 С. Баг, хорооны захиргаа 3. Эрүүл мэндийн даатгал
 Д. Хөдөлмөр нийгмийн халамж 4. Оршин суугаа газрын тодорхойлолт
- А.1А, 2С,3D,4В В.1В, 2D, 3А, 4С
 С.1С,2А,3В,4D Д.1D,2В,3С,4А

23. Цахим сүлжээний сөрөг талыг илэрхийлэх жишээ аль нь вэ?
 А. Хэн нэгнийг санаатайгаар доромжлох, хуурамч мэдээлэл тараах В. Өөрийн нэрээр хаяг нээх
 С. Цахим орчинд хүнтэй найз болох, мэдээлэл солилцох Д. Цахим орчинд бусдыг уруу татахгүй байх
24. Энэтхэгийн кастын тогтолцоог зөв тохируулна уу.

1. Брахман	2. Кшатри	3. Вайши	4. Шудра
а. Газаргүй тариачид. боолууд	б. Тариачид, УРЧУУД, худалдаачид	с. Хамгийн дээд эрх мэдэлтэй санваартнууд	д. Цэргийн жанжид, язгууртнууд

- А.1с, 2D, 3Б, 4а В.1Б, 2а, 3с, 4D С.1а, 2с, 3D, 4Б Д.1D, 2Б, 3а, 4с
25. ХҮ-ХҮIII зуунд өрнө дахины орнуудын төрийн засаглал, эзэмшил нутаг, хил хязгаар, эдийн засагт томоохон өөрчлөлтүүд гарч дэлхийн түүхэнд багагүй хувь нэмэр оруулсан. Энэ үед голлох байр суурь эзэлж байсан орнуудыг нэрлэж газрын зурагт тэмдэглэнэ үү.



- А.1-англи, 3-франц, 8-орос
 В.4- англи, 2-франц, 5-орос
 С.3-герман, 6-итал, 7-польш
 Д.4- англи, 3-франц, 5-орос

26. Ц хөдөө томиллолтоор яваад ирэх хугацаанаасаа 1 хоног хоцорч иртэл эхнэр нь уурлаж "Утас чинь ч ... холбогдохгүй, бас 1 хоног хаагуур яваад ирж байгаа юм" гэж ууртай асуулаа. Нөхөр "Машин эвдрээд ..."

- сүлжээгүй газар би яах юм” гэж ширүүн хариулав. Зөрчил үүсгэж буй өдөөгч хүчин зүйл аль нь вэ?
А.Шаардлага В.Бухимдал С.Шүүмжлэл D.Үгүйсгэл
27. **ХХЗууны дунд үед үүссэн, хамгийн хүртээмжтэй соёлын хэлбэр аль нь вэ?**
А.Ардын соёл В.Сонгодог соёл С.Дэлхийн соёл D.Нийтийн соёл
28. **БНМАУ НҮБ-д элссэний ач холбогдлыг тодорхойлж зөв хариултыг сонгоно уу.**
А.ОУ-ын энхийг сахиулах үйл ажиллагаанд оролцох эрхтэй болсон.
В.Монгол улсын хүн амын бичиг үсгийн боловсролыг хөгжүүлсэн.
С.Монгол Улс цөмийн зэвсэггүй бүс нутаг болсон.
D.ОУ-ын байгууллагуудын үйл ажиллагаанд идэвхтэй оролцох болсон.
29. **Ямар нэг үр ашигтай, үр дүнд чиглэсэн, хүний биеийн болон оюуны үйл ажиллагааг. гэнэ.**
А.Эдийн засаг В.Зах зээл С.Худалдаа D.Хөдөлмөр
30. **Хөдөлмөрийн үнэ цэнийг нэмэгдүүлэх , жижиг дунд үйлдвэрлэлийг дэмжих, ажилгүйдлийг бууруулах замаар .. хүү багатай урт хугацааны зээл олгох зэрэг нь ажилгүйдлийг бууруулах аль арга зам бэ?**
А.Эдийн засгийн В.Захиргааны С.Гадаад хүчин зүйлийг ашиглах D.Хувийн зохион байгуулалтын
31. **Хууль бүтээх үйл явцыг илэрхийлэх дараах үе шатуудаас хамгийн эхэнд нь байх үе шат аль нь вэ?**
А.УИХ чуулганаар хэлэлцэх В.Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
С.Хуулийн төсөл боловсруулах D.Байнгын хороогоор хэлэлцэх
32. **Илгээгчээс илгээсэн мэдээллийг хүлээн авч, ойлгох үйл явцыг юу гэж нэрлэдэг вэ?**
А. Тайлах В. Мэдээлэл дамжуулах суваг С. Саад D. Илэрхийлэх
33. **Монголчуудын мэндчилгээ нь олон төрөлтэй байдаг. “Сайхан зусаж байна уу” гэдэг нь монголчуудын мэндчилгээний аль төрөлд хамаарах вэ?**
.....
А. Баяр ёслолын мэндчилгээ В. Улирлын чанартай мэндчилгээ
С. Өдөр тутмын мэндчилгээ D. Ажил хөдөлмөрийн мэндчилгээ

ХОЁР. ЗАДГАЙ ДААЛГАВАР:

34. **Нэгэн улсад хувьсгал гарч, армийн генерал Ерөнхийлөгч болжээ. Ерөнхийлөгч хууль гаргаж, шүүгчдийг болон бусад төрийн албаны хүмүүсийг томиллоо. Таван жил тутамд ерөнхийлөгчийн сонгууль болно. Гэвч хэн ч ерөнхийлөгчтэй өрсөлдөхгүй.**

a. Дээрх жишээнд дурдагдаж буй улс нь төрийн ямар дэглэмтэй вэ?

b. Тус улсад явагдаж буй сонгуулийн онцлогийг тодорхойлно уу.

c. Дээрх улс дахь төрийн эрх мэдлийн онцлогийг тодорхойлно уу.

35. **Дараах эх сурвалжийг анхааралтай уншиж асуултад хариулна уу**

"Батмөнхийг долоон насанд нь Мандухай хатан барс жилээ даян бүгдийг эзлэх болтугай хэмээж, Батмөнх даян хаан хэмээн нэрийдэж эзний цагаан гэрийн өмнө суув" ... Батмөнхийг балчир учир түүний өмнөөс Монголын төрийг удирдаж эсэргүүцэл тэмцэл гаргагчдыг өөрийн биеэр цэрэглэн мордож нэгэн хааны жолоонд нэгтгэсэн юм. Батмөнх хаан Монголын төрийг хамгийн олон жил буюу 1470-1517 оны хооронд хаанчилсан байдаг. түүний хаанчилсан хугацааг сурвалжуудад зөрүүтэй тэмдэглэсэн байдаг. Батмөнх Даян хааны улс төрийн бодлого нь хаант төрийг бэхжүүлж, Монгол улсын төрийн нэгдлийг хангахад чиглэгдэж байжээ. Сурвалж бичгүүдэд энэхүү үеийг «гар газар, хөл хөсөр» байсан үе гэж нэрлэжээ. Өөр зуураа удтал хямралдан байсан монголчууд нэгэн хааны эрхэнд орж захирагдах болсон нь юуны урьд нийт Монголын тусгаар тогтнох байдлыг бэхжүүлж, нөгөөтэйгүүр үйлдвэрлэхүй хүчний хөгжилд тус дөхөм болсон.

a. Даян хаан Монголын төрийг хэдэн жил захирч байсан бэ?

b. Батмөнх бага балчир байсан тул түүний өмнөөс хэн төрийн үйл хэргийг удирдаж байсныг тэмдэглэнэ үү.

c. Даян хаан хэмээн алдаршсаны учрыг тайлбарлан бичнэ үү?

d. Батмөнх даян хааны төр барьж байсан жилүүдийг сурвалжид “Гар газар, хөл хөсөр байсан үе” хэмээдэг. Үүний утгыг тайлбарлан бичнэ үү?

e. Даян хаан Чингисийн онгоны 8 цагаан гэр(эзний цагаан гар)-ийн өмнө тангараг өргөсөн шалтгааныг тайлбарлана уу.

f. Батмөнх даян хааны төр барьсан оны зуунд шилжүүлнэ үү

Даал гавар	Оноо	Суралцагчийн хариулт	Багшийн үнэлгээ
1	1		
2	1		
3	1		
4	1		
5	1		
6	1		
7	1		
8	1		
9	1		
10	1		
11	1		
12	1		
13	1		
14	1		
15	1		
16	1		
17	1		
18	1		
20	1		
21	1		
22	1		
23	1		
24	1		
25	1		
26	1		
27	1		
28	1		
29	1		
30	1		
31	1		
32	1		
33	1		
34	1		
	2		
	2		
35	2		
	2		
	2		
	2		
	2		
	2		

Нийт авсан оноо:

Гүйцэтгэлийн хувь:

Үр дүнгийн үнэлгээний түвшин:

Шалгасан багшийн нэр, гарын үсэг: